

Living the

LOTUS

Buddhism in Everyday Life

11
2017

VOL. 146

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧИЙН СУРГААЛ

Бусдын ачийг хариулах

Буддын шашны үндэс нь аливаа юмс үзэгдэл заавал ямар нэг зүйлтэй холбогдож үүсэн бий болдог гэсэн шүтэн барилдлагын сургаал гэдгийг та бүхэн сайн мэдэж байгаа. Энэ сургаалыг амьдралд хэрхэн хэрэгжүүлбэл зохилтой юм бол?

Юуны түрүүнд өнөөдөр нэг өдрийг эрүүл энх өнгөрөөсөн нь хэний ач вэ, хичнээн их хүнээс тусламж дэмжлэг авч байгаа вэ гэдгийг ухаарах нэн чухал. Энэхүү шүтэн барилдлагыг ойлгох нь бусдын ачийг хариулах эхний алхам болно.

Хүмүүс бид ажил үйлс бүтэмжтэй үед бүх юм өөрийн хүчээр бүтэж байна, өөрийн хичээл зүтгэлийн үр дүн гэж бодон өөрөөрөө бахархдаг. Гэвч түүний ард

хичнээн олон хүний оролцоо дэмжлэг байсныг өдөр бүр бодож үзэх хэвшилтэй болох чухал. Өглөө, оройн судар уншлага нь ийнхүү бодож тунгаах нэг боломж болдог.

Эргэн тойрныхоо хүмүүст үргэлж талархаж, тэр сэтгэлээ байгаагаар нь илэрхийлж амьдрах ба өөртөө хэт итгэн бардамнаж, хичээж зүтгэснийхээ төлөө хариу нэхэн хонзогnoj амьдрах хоёрын хооронд тэнгэр газар шиг том ялгаа бий.

Өвөг дээдсийн ном, эцэг эхээ ачлах, бодисадвагийн үйл нь бүгд өнөөдөр биднийг амьдруулж байгаа бүх зүйлийн ачийг хариулах үйл юм.

Living the Lotus Vol. 146 (2017.11)

Хэвлэсэн: Рисшо Косей Кай, Олон улсын хэлтэс

Хаяг: Fumon Media Center, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo 166-8537 Japan

TEL: +81-3-5341-1124

FAX: +81-3-5341-1224

Email: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Ахлах редактор: Мизүтани Шёокоо

Орчуулсан: Ж.Гэрэлтуяа

Эхийг хянасан: Монголын РКК

Рисшо Косей кай байгууллага нь Үүсгэн байгуулагч Нивано Никкёо болон түүний шавь Хамтран үндэслэгч Наганүма Мёокоо нарын санаачлагаар 1938 онд байгуулагдсан ба “Гурван Эрдэнийн Цагаан Лянхуа Судар”-ыг гол сургаал номлолоо болгодог, лам бус эгэл хүмүүс нэгдсэн буддын шашны байгууллага юм. Өөрөөр хэлбэл Шагжамүни бурхан багшийн сургаалыг гэр бүл, ажил, нийгмийн амьдралдаа хэрэгжүүлж, дэлхийн энх тайвныг бүтээн байгуулья гэсэн хүсэл зорилготой хүмүүсийн нэгдэл юм. Гишүүд бид бурхан багшийн шавь болохынхоо хувьд тус байгууллагын Ерөнхийлөгч Нивано Ничикоогийн удирдлага дор бурханы сургаалыг түгээх үйлсэд зүтгэж, шашны төдийгүй бусад салбарын байгууллагууд, дэлхийн олон орны хүмүүстэй сэтгэл нэгдэн, энх тайвны олон янзын үйл ажиллагаа явуулж байна.

Living the Lotus – Buddhism in Everyday Life (Амьд Цагаан Лянхуа судар – Буддизм бидний амьдралд)” хэмээх тус сэтгүүлийн нэрэнд, Цагаан лянхуа судрын сургаалыг өдөр тутмынхаа амьдралд хэрэгжүүлж, шаварт ургадаг үзэсгэлэнт лянхуа цэцэг мэт үр бүтээмжтэй, үнэ цэнэтэй амьдралыг туулцаага гэсэн хүсэл шингэсэн билээ. Бид энэхүү сэтгүүлээр дамжуулан өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлж болох бурханы сургаалыг дэлхийн өнцөг булан бүрт хүргэж байна.

Эцэг эхээ ачлах ба бодисадвагийн үйл хийх

Рисшо Косей Кай, Ерөнхийлөгч
Нивано Ничикоо



Эцэг, эхээ ачлахад “оройтсон” гэсэн ойлголт байхгүй


Эцэг, эхээ хүндэлж, асран халамжлахыг “эцэг эхээ ачлах” гэдэг. “Эцэг эхээ ачлах гэтэл тэд нар нь хэдийн бурханы оронд одсон байдаг” хэмээх зүйр үгнээс үзвэл эцэг эхээ амьд сэрүүн байхад нь ачлах ёстой гэж нийтээрээ боддог бололтой.

Гэвч ихэнх хүмүүс эцэг эхээ амьд сэрүүн байхад нь тэр болгон асран тойлж чаддаггүй. Бага зэрэг нэрэлхэх сэтгэлээс гадна эцэг эхээ үргэлж эрүүл саруул байх юм шиг боддог тал ч байж болох юм. Тэгээд бурханы оронд одсон хойно нь эцэг эхийн ач буян ямар их байсныг ухаарч, амьд байхад нь ачилж чадаагүйдээ шаналах хүн цөөнгүй.

Харин би эцэг эхээ ачлахад хэзээ ч оройтдоггүй гэж боддог юм.

Би өмнө нь тус сэтгүүлийн 2011 оны 7 сарын дугаарт “эцэг эх, өвөг дээдсээ сэтгэл амар байлгахаар амьдарцгаая” гэсэн нийтлэл бичиж байсан. Энэ нийтлэлээрээ амьдралд тохиолдох аливаа зүйлд үнэн сэтгэлээсээ хандаж, өдөр бүрийг гэгээлэг, өөдрөг өнгөрөөн, хүнийг баярлуулах үйлийг хичээнгүйлэн хийх нь эцэг эхээ баярлуулж, тэднийгээ ачилж байна гэсэн үг гэдгийг ойлгуулахыг зорьсон хэрэг. Үр хүүхэд нь ингэж амьдарч байх юм бол бурхан болсон эцэг эх нь ч гэсэн амар амгалан байхгүй гэж үү. Энэ утгаараа эцэг эхээ ачлахад оройтно гэсэн зүйл байхгүй юм. Амьд сэрүүн байгаа эцэг эхийн хувьд ч гэсэн үр хүүхэд нь үнэнч шударга, хүмүүсийг баярлуулж амьдарвал тэд юунаас ч илүү баярлах нь лавтай.

Бурхан тахил, өвөг дээдэстээ мөргөх нь ч гэсэн мэдээж хэрэг эцэг эхээ ачилж байна гэсэн үг. Энэ нь эцэг эх, өвөг дээдэстээ мөргөж байгаагаас гадна ингэж мөргөж байна гэдэг нь “амь насныхаа эх үндэст талархаж чаддаг хүн” болон өсөж хөгжсөнийг харуулж байгаа болохоор юм.





“Эцэг эхээ ачлах нь мянган сайн үйлийн үндэс”

Үүсгэн байгуулагч Цагаан лянхуа судрын сургаалыг амьдралдаа хэрэгжүүлбэ гэвэл “эцэг эхээ ачлах”, “өвөг дээдсийн ном унших”, “бодисадвагийн үйл хийх” нь хамгаас чухал хэмээн айлдсан байдаг. Эцэг эхээ ачлах нь өвөг дээдсийн номтой утга ижил тул манай байгууллагын сургаал нь товчоор “эцэг эхээ ачлах” ба “бодисадвагийн үйл хийг”-ийг сургадаг гэж хэлж болно.


Тэгвэл бодисадвагийн үйл гэж юу юм бол? Энэ нь өглөг, шагшаабад, хүлцэнгүй зэрэг бурханы сургаалыг хэрэгжүүлэн хүнийг энэрэн нигүүлсэж, эргэн тойрныхоо хүмүүсийг баярлуулах үйл хийхийг хэлнэ. Өөрөөр хэлбэл хүмүүсийг баярлуулснаар өөрөө баяр хөөрийг мэдэрдэг хүнийг бодисадва гэх ба ийм хүн байхын үндэс нь олон зүйлийн ачаар амьд яваадаа талархаж чаддаг байх явдал юм.

Одоо эцэг эхээ ачлах талаар дахин тунгааж үзэцгээе. Амьдралд тохиолдох аливаа зүйлд чин сэтгэлээсээ хандаж, үнэнч шударга байж, хүмүүсийг баярлуулж амьдрах нь эцэг эхээ ачилж байгаа хэрэг бөгөөд энэ нь бодисадвагийн үйлтэй утга нэг болж байна. Ингээд бодоод үзэхээр эцэг эхээ ачлах, өвөг дээдсийн ном унших, бодисадвагийн үйл хийх гурав нь үндсэндээ нэг л зүйлийг хэлээд байгаа юм. Түүнчлэн энэ гурван үйлийн нийтлэг зүйл нь одоо амьд байгаадаа “талархах” явдал билээ.

“Эцэг эхээ ачлах нь мянган сайн үйлийн үндэс” гэсэн зүйр үг байдаг. Энэ нь “эцэг эхээ сэтгэл амар байлгахын тулд хүн муу үйл хийхгүй, сайн үйл хийхийг хичээдэг тул эцэг эхээ ачлах нь сайн үйл хийх үндэс болдог” гэсэн утгатай. Төрүүлж өсгөсөн аав ээждээ талархах нь эцэг эхээ ачлах үйл тул амь насны эх үндэст талархах нь бүх сайн үйлийн тулгуур болно. Тиймээс дээрх зүйр үг эцэг эхээ ачлах нь сайн сайхан нийгмийг бүтээн байгуулах үндэс болно хэмээн сургасан утгатай гэж хэлж болох юм.

Манай байгууллагын ажлын шинэ он 12 сард эхэлдэг уламжлалтай тул бид удахгүй байгууллагынхаа 80 жилийн ойг угтах гэж байна. Би жилийн сүүлийн сард байгууллагын чухалчилж ирсэн “эцэг эхээ ачлах ба бодисадвагийн үйл хийх” талаар өгүүлсэн нь үүгээр дамжуулж амь насныхаа эх үндсийг эргэн харж, сүсэг бишрэлийнхээ талаар дүгнэж цэгнэх боломж болоосой хэмээн бодсон хэрэг. Түүнчлэн илүү олон хүнд бурханы номыг дамжуулах гэсэн бодисадвагийн үйлийн утга учрыг дахин тунгаан бодож, амь насыг хүртэх ямар сайхан болохыг хамтдаа амталцгаая.

“Косей” сэтгүүл 11-р сарын дугаараас



Хүүхдийнхээ юм шидлэхийг яаж болиулах вэ?

Q

Ой долоон сартай охин маань тоглоом гэх мэт гартаа тааралдсан болгоныг шидлээд байх юм. Тэр болгонд нь загнадаг боловч хэт загнаад байж болохгүй байх гэж бодох юм. Гэхдээ загнахгүй байгаад байхаар улам юм шидлээд байх юм болов уу гэж бас санаа зовох юм. Ямар үед загнаж, ямар үед загнахгүй байх вэ гэдгийг сайн мэдэхгүй байна.



A

Ой долоон сартай хүүхдийн хөдөлгөөн ихэсдэг тул юм авч шидлэх үйлдэл нь уурандаа тэгэж байгаа хэрэг биш, янз бүрийн үйлдэл хийх нь сонирхолтой байгаа болохоор юм. Харин хөдөлгөөнөө л зохицуулж чадахгүй байгаа хэрэг.

Тиймээс юм шидлэх үед нь загнаж зандралгүй “энэ эвдэрчихвэл хайран шүү дээ, эвий эвий гээрэй” гэж сэтгэл гарган хүмүүжүүлэх чухал.

Энэ насны хүүхэд “сайн, муу” зүйлийг “дуртай, дургүй” гэсэн мэдрэмжээр хүлээж авдаг. Сэтгэлд таатай зүйлийг улам бүр хийж, таагүй мэдрэмж төрсөн зүйлийг хийхээ болино. Хүүхэд тань болохгүй зүйл хийсэн үед “ээж нь гомдож байна” гэж хэлээд сэтгэлээсээ гомдож байгаа царай гаргах. эсвэл ууртай царай гаргаж “энэ болохгүй” гэж хэлэх, чанга цохиж, чимхэлгүй гарыг нь зөөлхөн цохиод үйл хөдлөлөөрөө илэрхийлсэн ч болно. Эсрэгээр юманд гамтай хандах үед нь нүүр дүүрэн инээмсэглэж “сайн охин шүү, ээж нь баяртай байна” гэж хэлэх хэрэгтэй. Гэхдээ хүмүүжүүлэхийн тулд ингэж хэлэх биш чин

сэтгэлээсээ ингэж бодож байгаа юм шүү гэсдээ хайр гэрэлтсэн төрх, үг хэлээрээ дахин дахин ойлгуулах чухал. Бага насны хүүхдийг хүмүүжүүлэх гол арга барил бол “сэтгэлээсээ дахин дахин хэлэх” юм.

Мөн хүрч болохгүй зүйл байвал далд хийх зэргээр арга хэмжээ аваарай.



Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт

Токио гэр бүлийн сургалт, судалгааны институт нь “Эцэг эх өөрчлөгдөх юм бол хүүхэд ч гэсэн өөрчлөгдөнө” гэсэн сурган хүмүүжүүлэх арга ухаанд тулгуурлан газар газарт сургалт семинар зохион байгуулж, хүүхэд өсгөн хүмүүжүүлэх талаар зөвөлгөө өгч байна. Үүгээр дамжуулан олон хүмүүс хүүхдээрээ дамжуулан гэр бүл гэж ямар байдгийг суралцаж, аз жаргалтай гэр бүл олноор төрж байна.



Сайхан харилцааг бий болгох

Та хүүхдээ өсгөж хүмүүжүүлэхийн төлөө хичээж байгаа гайхалтай ээж байна.

Ой долоон сартай хүүхэд ярьж чадахгүй ба хэлсэн зүйлийг тийм хурдан ойлгохгүй. Тийм үед өмнө хэлсэлчлэн сэтгэлд таатай, таагүй гэсэн байгалийн мэдрэмжинд нь тулгуурлан дахин дахин хэлэхээс өөр аргагүй. Мөн чухал зүйл бол сайхан харилцааг бий болгох юм.

Буддын шашинд аливаа зүйл нөхцөл ямар байхаас шалтгаалдаг гэсэн шүтэн барилдлагын сургаал байдаг.

Бидний амьдарч байгаа энэ дэлхий ертөнц хором мөч бүрт хувиран өөрчлөгдөж байдаг. “Аливаа юмс үзэгдэл анхны нөхцөл сайхан байх юм бол сайн тал руу хувирч, муу байх юм бол муу тал руу хувирна гэсэн байгалийн хуулийн дагуу үүсэн бий болж байдаг.”

Хүүхдээ юм шидэх болгонд нь сэтгэлээ шингээн “энэ эвдэрчихвэл хайран шүү дээ, эвий эвий гээрэй” гэж дахин дахин хэлж, сайхан нөхцлийг бий болгох хэрэгтэй. Хүүхдийн хувьд ээжийнх нь баярлаж байгаа царай юунаас ч илүү сэтгэлийн дэм болдог. Юманд гамтай хандах үед нь баярласан сэтгэлээ бүрэн дүүрэн илэрхийлээрэй.

РКК, Сургалтын алба



Please give us your comments!



We welcome comments on our e-newsletter Living the Lotus.

E-mail: living.the.lotus.rk-international@kosei-kai.or.jp

Эцэг эхээ амар тайван байлгахаар амьдрах


“Эцэг эхээ бурханы оронд одсоны дараа Цагаан лянхуа судрын сургаалыг сурч, бодисадвагийн үйл хийж, хүмүүсийг баярлуулдаг хүн болох нь жинхэнэ утгаараа эцэг эхээ ачилж байна гэсэн үг юм.”

11 сарын 1-нд гадаад салбарын санга нарыг төлөөлөн Солонгос салбарын дүүргийн ахлагч Сон Их ариун ордонд илтгэл тавьсан юм. Аав нь 1 настайд нь бурхан болж, ээж нь гэр бүлээ тэжээхийн тулд хот газар ажиллахаар явсан тул өвөө эмээ дээрээ өссөн байна. Өсвөр наснаасаа ээжтэйгээ хамт амьдарч эхэлсэн боловч үргэлж ээжийгээ эсэргүүцдэг байж. 27 настайдаа гэрлэж, 2005 онд гишүүн болсон байна. 2 жилийн өмнө асарч байсан хадам ээж нь бурхан болж, түүнээс 4 сарын дараа төрсөн ээж нь өөд болжээ. Тэр үед “бүх амьдралаа миний төлөө зориулсан ээжийгээ цаашид ачлах болно” хэмээн шийдсэн байна. Амьдад нь ачилж чадаагүйдээ уйлын их харамсаж, өөрийгөө буруутгасан байна. Яг энэ үед дээрх ерөнхийлөгчийн сургаалыг сонсоод сэтгэл нь тайвширчээ.

Тэрээр “Би ариун нандин амь насыг олсон мөртлөө буруу амьдралаар амьдрах байсан байж ч магадгүй. Азаар РКК байгууллагатай учирч, сэтгэлээ сайжруулахыг зорин «эхлээд бусад хүмүүс» гэдгийг хэрэгжүүлэн гайхалтай сайхан амьдарч байна” хэмээн одоогийн байгаа сэтгэлээ баярлан хуваалцсан юм.

Бурхан болсон эцэг эх нь охиноо ийм мундаг хүн болсныг хараад баярлаж, бахархаж байгаа гэдэгт итгэлтэй байна. Би ч гэсэн бурхан болсон эцэг эхээ амар тайван байлгахаар амьдаръя хэмээн бодож байна.

РКК, Олон улсын хэлтсийн дарга
Мизүтани Шёокоо



RISSHO KOSEI-KAI INTERNATIONAL BRANCHES

Rissho Kosei-kai Overseas Dharma Centers

2017

Rissho Kosei-kai International

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of North America (RKINA)

2707 East First Street Suite #1 Los Angeles CA 90033 U.S.A.
Tel: 1-323-262-4430 *Fax:* 1-323-262-4437
e-mail: info@rkina.org <http://www.rkina.org>

Branch under RKINA

Rissho Kosei-kai of Seattle's Buddhist Learning Center

28621 Pacific Highway South, Federal Way,
WA 98003 U.S.A.
Tel: 1-253-945-0024 *Fax:* 1-253-945-0261
e-mail: rkseattlewashington@gmail.com
<http://buddhistlearningcenter.org/>

Rissho Kosei-kai Buddhist Center of San Antonio

6083 Babcock Road, San Antonio, TX 78240, U.S.A.
P.O. Box 692148, San Antonio, TX 78269, USA
Tel: 1-210-561-7991 *Fax:* 1-210-696-7745
e-mail: dharmasanantonio@gmail.com
<http://www.rkina.org/sanantonio.html>

Rissho Kosei-kai of Tampa Bay

2470 Nursery Road, Clearwater, FL 33764, U.S.A.
Tel: (727) 560-2927 *e-mail:* rktampabay@yahoo.com
<http://www.buddhismtampabay.org/>

Rissho Kosei-kai of Vancouver

Rissho Kosei-kai Buddhist Church of Hawaii

2280 Auhuhu Street, Pearl City, HI 96782, U.S.A.
Tel: 1-808-455-3212 *Fax:* 1-808-455-4633
e-mail: info@rkhawaii.org <http://www.rkhawaii.org>

Rissho Kosei-kai Maui Dharma Center

1817 Nani Street, Wailuku, HI 96793, U.S.A.
Tel: 1-808-242-6175 *Fax:* 1-808-244-4625

Rissho Kosei-kai Kona Dharma Center

73-4592 Mamalahoa Highway, Kailua-Kona,
HI 96740 U.S.A.
Tel: 1-808-325-0015 *Fax:* 1-808-333-5537

Rissho Kosei-kai Buddhist Center of Los Angeles

2707 East First Street, Los Angeles, CA 90033, U.S.A.
Tel: 1-323-269-4741 *Fax:* 1-323-269-4567
e-mail: rk-la@sbcglobal.net <http://www.rkina.org/losangeles.html>

Rissho Kosei-kai Buddhist Center of Arizona

Rissho Kosei-kai Buddhist Center of Colorado
Rissho Kosei-kai Buddhist Center of San Diego
Rissho Kosei-kai Buddhist Center of Las Vegas
Rissho Kosei-kai Buddhist Center of Dallas

Rissho Kosei-kai of San Francisco

1031 Valencia Way, Pacifica, CA 94044, U.S.A.
Tel: 1-650-359-6951 *Fax:* 1-650-359-6437
e-mail: info@rksf.org <http://www.rksf.org>

Rissho Kosei-kai of Sacramento

Rissho Kosei-kai of San Jose

Rissho Kosei-kai of New York

320 East 39th Street, New York, NY 10016 U.S.A.
Tel: 1-212-867-5677 *Fax:* 1-212-697-6499
e-mail: rkny39@gmail.com <http://rk-ny.org/>

Rissho Kosei-kai of Chicago

1 West Euclid Ave., Mt. Prospect, IL 60056 U.S.A.
Tel: 1-773-842-5654 *e-mail:* murakami4838@aol.com
<http://home.earthlink.net/~rkchi/>

Rissho Kosei-kai of Fort Myers

<http://www.rkftmyersbuddhism.org/>

Rissho Kosei-kai Dharma Center of Oklahoma

2745 N.W. 40th Street, Oklahoma City, OK 73112 U.S.A.
Tel & Fax: 1-405-943-5030
e-mail: rkokdc@gmail.com <http://www.rkok-dharmacenter.org>

Rissho Kosei-kai, Dharma Center of Denver

1255 Galapago Street, #809 Denver, CO 80204 U.S.A.
Tel: 1-303-446-0792

Rissho Kosei-kai Dharma Center of Dayton

425 Patterson Road, Dayton, OH 45419 U.S.A.
<http://www.rkina-dayton.com/>

Rissho Kosei-kai do Brasil

Rua Dr. José Estefno 40, Vila Mariana, São Paulo-SP,
CEP 04116-060 Brasil
Tel: 55-11-5549-4446 / 55-11-5573-8377
Fax: 55-11-5549-4304
e-mail: rissho@terra.com.br <http://www.rkk.org.br>

Rissho Kosei-kai de Mogi das Cruzes

Av. Ipiranga 1575-Ap 1, Mogi das Cruzes-SP,
CEP 08730-000 Brasil
Tel: 55-11-5549-4446/55-11-5573-8377

Rissho Kosei-kai of Taipei

4F, No. 10 Hengyang Road, Zhongzheng District,
Taipei City 100 Taiwan
Tel: 886-2-2381-1632 *Fax:* 886-2-2331-3433
<http://kosei-kai.blogspot.com/>

Rissho Kosei-kai of Taichung

Rissho Kosei-kai of Tainan

No. 45, Chongming 23rd Street, East District,
Tainan City 701 Taiwan
Tel: 886-6-289-1478 *Fax:* 886-6-289-1488

Rissho Kosei-kai of Pingtung

Korean Rissho Kosei-kai

6-3, 8 gil Hannamdaero Yongsan gu, Seoul, 04420, Republic of Korea
Tel: 82-2-796-5571 *Fax:* 82-2-796-1696
e-mail: krkk1125@hotmail.com

Korean Rissho Kosei-kai of Busan

3F, 174 Suyoung ro, Nam gu, Busan, 48460, Republic of Korea
Tel: 82-51-643-5571 *Fax:* 82-51-643-5572

Branches under the Headquarters

Rissho Kosei-kai of Hong Kong

Flat D, 5/F, Kiu Hing Mansion, 14 King's Road,
North Point, Hong Kong, Republic of China

Rissho Kosei-kai of Ulaanbaatar

15F Express tower, Peace avenue, khoroo-1, Chingeltei district,
Ulaanbaatar 15160, Mongolia
Tel: 976-70006960 *e-mail:* rkkmongolia@yahoo.co.jp

Rissho Kosei-kai of Sakhalin

4 Gruzinski Alley, Yuzhno-Sakhalinsk
693005, Russian Federation
Tel & Fax: 7-4242-77-05-14

Rissho Kosei-kai di Roma

Via Torino, 29-00184 Roma, Italia
Tel & Fax : 39-06-48913949 *e-mail:* roma@rk-euro.org

Rissho Kosei-kai of the UK

Rissho Kosei-kai of Venezia

Rissho Kosei-kai of Paris

International Buddhist Congregation (IBC)

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1230 *Fax:* 81-3-5341-1224
e-mail: ibcrk@kosei-kai.or.jp <http://www.ibc-rk.org/>

Rissho Kosei-kai of South Asia Division

Fumon Media Center 3F, 2-7-1 Wada, Suginami-ku, Tokyo, Japan
Tel: 81-3-5341-1124 *Fax:* 81-3-5341-1224

Rissho Kosei-kai International of South Asia (RKISA)

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218
e-mail: thairissho@csloxinfo.com

Branches under the South Asia Division

Rissho Kosei-kai of Central Delhi

224 Site No.1, Shankar Road, New Rajinder Nagar, New Delhi,
110060, India

Rissho Kosei-kai of West Delhi

66D, Sector-6, DDA-Flats, Dwarka, New Delhi 110075, India

Rissho Kosei-kai of Kolkata

E-243 B. P. Township, P. O. Panchasayar, Kolkata 700094, India

Rissho Kosei-kai of Kolkata North

AE/D/12 Arjunpur East, Teghoria, Kolkata 700059,
West Bengal, India

Rissho Kosei-kai of Bodhgaya Dharma Center

Ambedkar Nagar, West Police Line Road
Rumpur, Gaya-823001, Bihar, India

Rissho Kosei-kai of Kathmandu

Ward No. 3, Jhamsilhel, Sancepa-1, Lalitpur,
Kathmandu, Nepal

Rissho Kosei-kai of Phnom Penh

#201E2, St 128, Sangkat Mittapheap, Khan 7 Makara,
Phnom Penh, Cambodia

Rissho Kosei-kai of Patna Dharma Center

Rissho Kosei-kai of Singapore

Thai Rissho Friendship Foundation

201 Soi 15/1, Praram 9 Road, Bangkapi, Huaykhwang
Bangkok 10310, Thailand
Tel: 66-2-716-8141 *Fax:* 66-2-716-8218 *e-mail:* info.thairissho@gmail.com

Rissho Kosei-kai of Bangladesh

85/A Chanmari Road, Lalkhan Bazar, Chittagong, Bangladesh
Tel & Fax: 880-31-626575

Rissho Kosei-kai of Dhaka

House#408/8, Road#7(West), D.O.H.S Baridhara,
Dhaka Cant.-1206, Bangladesh
Tel: 880-2-8413855

Rissho Kosei-kai of Mayani

Mayani(Barua Para), Post Office: Abutorab, Police Station: Mirshari,
District: Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Patiya

Patiya, sadar, Patiya, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Domdama

Domdama, Mirsarai, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Cox's Bazar

Ume Burmese Market, Main Road Teck Para, Cox'sbazar, Bangladesh

Rissho Kosei-kai of Satbaria

Satbaria, Hajirpara, Chandanish, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Laksham

Dupchar (West Para), Bhora Jatgat pur, Laksham, Comilla,
Bangladesh

Rissho Kosei-kai of Raozan

West Raozan, Ramjan Ali Hat, Raozan, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Chendirpuni

Chendirpuni, Adhunagor, Lohagara, Chittagong, Bangladesh

Rissho Kosei-kai of Ramu

Rissho Kosei Dhamma Foundation, Sri Lanka

No. 628-A, Station Road, Hunupitiya, Wattala, Sri Lanka
Tel: 94-11-2982406 *Fax:* 94-11-2982405

Rissho Kosei-kai of Habarana

151, Damulla Road, Habarana, Sri Lanka

Rissho Kosei-kai of Polonnaruwa

Other Groups

Rissho Kosei-kai Friends in Shanghai